



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/565

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоол, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/518 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээр хэсэгт Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын газар (9073299) татан буугдсантай холбоотой тус байгууллагад эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар баг Согоот-1 104 тоотод байршилтай 6712016126 нэгж талбарын дугаар бүхий төрийн захиргааны байгууллагын зориулалттай 368 м<sup>2</sup> газрыг Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс (4125223)-т шилжүүлж үлдсэн 12 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/518 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээр хэсгийг хүчингүй болгосугай.
3. Захирамжаар газар эзэмшигч Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс (4125223)-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.
4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.
5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ